МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 3 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ

№	*Хэлэлцсэн асуудал*	*Хуудасны дугаар*
1.	***Хуралдааны товч тэмдэглэл:***	1-16
2.	***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:***	17-87
	1.* Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд** */Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх/	18-33
	2.* Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд** */Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг/	33-61
	3. Улсын дээд шүүхээс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах санал	61-87

Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 3 дугаар сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Байнгын хорооны хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар "Их эзэн Чингис хаан" танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан Байнгын хорооны хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 15 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 78.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 19 минутад Төрийн ордны "Их эзэн Чингис хаан" танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал.

Хоёр.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар “Их эзэн Чингис хаан” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн газрын

Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, хуулийн төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Төслийн 2, 4, 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ш.Адьшаа, Д.Цогтбаатар, Ж.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, хамтран ажиллах, Хүний эрх хамгаалагчийн хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Үндсэн хууль," гэсний дараа "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль" гэж нэмж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн "нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа" гэснийг "нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан, явуулж байгаа" гэж, "тодорхойлно." гэснийг "зохицуулна." гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ш.Адьшаа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсгийг нэмэх:

“3.2.Гадаад улсын нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэний эрх зүйн байдлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хүний эрх хамгаалагч” гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;

4.1.2.“хүний эрх хамгаалах үйл ажиллагаа” гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалах;

4.1.3.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” гэж төр, хүн, хуулийн этгээд, тодорхой ашиг сонирхлоор нэгдсэн аливаа этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн байгууллагын үүргийг;

4.1.4.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага хүн, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;

4.1.5.“хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж Хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг аливаа хэлбэрээр доромжлох, гүтгэх, худал

мэдээлэл тараах, ялгаварлан гадуурхах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөж мөшгөх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.6.“эрсдэлийн үнэлгээ” гэж хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчид учирч буй аюул, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон дүгнэлтийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**5 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

5.1.Хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.1.1.Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх;
5.1.2.шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх;
5.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
5.1.4.ялгаварлан гадуурхахгүй байх;
5.1.5.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн ХОЁРДУГААР БҮЛГИЙН гарчгийн “ХАМГААЛАГЧИЙН ЭРХ,” гэсний дараа “САНХҮҮЖИЛТ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “хамгаалахад” гэснийг “хамгаалах үйл ажиллагаа явуулах, сайн дураар” гэж, 6.1.2 дахь заалтын

“таниулах, тэдгээрийг” гэснийг “олон нийтэд таниулах,” гэж өөрчилж, төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хүний эрх хамгаалагч дараах бүрэн эрхтэй:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон гадаад улсын, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.7.хуулийн дагуу нуцад хамааруулснаас бусад мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдээс хуульд заасан аргаар хайх, олж авах, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “үүнийгээ хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх,” гэснийг, 6.1.10 дахь заалтын “төрийн үйл хэрэгт оролцох,”, “шүүмжлэх,”, “зөвлөмж хүргүүлэх,” гэснийг, 6.1.13 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэснийг, мөн зүйлийн 6.1.4, 6.1.14, 6.1.15, 6.1.18 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.16 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын “этгээдийн” гэсний дараа “бичгээр гаргасан” гэж, 6.1.12 дахь заалтын “үйлдлийн талаар” гэсний дараа “холбогдох олон улсын гэрээнд заасан журмын дагуу” гэж нэмж, 6.1.13 дахь заалтын “олон улсын холбогдох хэм хэмжээг” гэснийг “Монгол Улсын олон улсын гэрээг” гэж, 6.1.17 дахь заалтын “сэтгэл санааны болон бодит хохирлоо” гэснийг “эдийн болон эдийн бус хохирлоо хуульд заасан журмын дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн “**ХОЁРДУГААР БҮЛЭГ**”-т доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“**7 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод, нээлттэй байдал.**

7.1.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон аливаа санхүүгийн нөөц, эх үүсвэр ил тод, нээлттэй байх бөгөөд санхүүгийн нөөц дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

7.1.2.хуульд заасны дагуу төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;

7.1.3.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

7.2.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүжилтэд дараах нөөц, эх үүсвэрийг хориглоно:

7.2.1.Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно;

7.2.2.хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3

Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж, 7.1.3 дахь заалтын “хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх, зөрчих” гэснийг “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн Гуравдугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“ГУРАВДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

8 дугаар зүйл.Нийтлэг үүрэг

8.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх;

8.1.2.үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;
8.1.3.хүчирхийллийн бус, тайван аргаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх;

8.1.4.шаардлагатай мэдээллээр хангах;
8.1.5.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрх хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;

8.1.6.хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах;

8.1.7.хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг бичгээр гомдол гаргагчид болон Хүний эрх хамгаалагчийн хороонд хүргүүлэх.

8.2.Цагдаагийн байгууллага хүний эрх хамгаалагчид халдсан халдлагыг таслан зогсоох, түүнийг өөрийнх нь зөвшөөрснөөр эсхүл энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авна.

8.3.Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ж.Ганбаатар нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**10 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хороо**

10.1.Хүний эрхийн Үндэсний Комиссын /цаашид “Комисс” гэх/ дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо (цаашид “Хороо” гэх) ажиллана.

10.2.Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Хорооны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.

10.3.Хороо үйл ажиллагаагаа бие даан явуулах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах;

10.3.2.гомдол мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах;

10.3.3.хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх;

10.3.4.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комисст хүргүүлэх;

10.3.5.энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах;

10.3.6.гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх.

10.4.Хороо нь энэ хуулийн 10.2-т заасан даргаас гадна зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 11.3-т заасан хоёр нэр

дэвшигчийг шууд, бусад дөрвөн гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс нэр дэвшүүлэн, нээлттэй сонсголоор сонгон шалгаруулж, Комисс батламжилна.

10.5.Хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо жендэрийн тэнцвэртэй байдал болон үндэсний хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчийн олон талт төлөөллийг хангана**.**

10.6.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

10.7.Хорооны гишүүн улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

10.8.Хорооны үйл ажиллагааны урсгал зардлыг Комиссын төсөвт тусгах бөгөөд Хорооны гишүүнд урамшуулал олгох журмыг Комисс батална.

10.9.Хорооны ажиллах журмыг Комисс батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:

11.1.1.хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай;

11.1.2.хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм, хэмжээний талаар мэдлэг, туршлагатай;

11.1.3.сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11.2, 11.3 дахь хэсэг болгох:

“11.2.Хорооны гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс дараах үе шатаар сонгоно:

11.2.1.Комисс нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Комисс, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

11.2.2.ажлын хэсэг Хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30 хоногийн хугацаанд нийтэд мэдээлэх;

11.2.3.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.2-т заасан хугацаа дуусанаас хойш ажлын гурван өдрийн дотор сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчийн хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг Комиссын цахим хуудаст байршуулах;

11.2.4.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.3-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах;

11.2.5.Ажлын хэсэг энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулах;

11.2.6.Ажлын хэсэг нээлттэй сонсгол зохион байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор нууц санал хураалт явуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор Хорооны гишүүнээр сонгох.

11.3.Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Комисс батална." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"11.5.Хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.3 дахь заалтын "гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон" гэснийг "гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон." гэж, 11.7 дахь хэсгийн "Хороо боловсруулж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос баталж, мөрдүүлнэ." гэснийг "Комисс батална." гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

"**12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хорооны нэгж**

12.1.Хорооны гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах бөгөөд бүтэц, орон тоог Комисс батална.

12.2.Хорооны нэгжийн ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

12.3.Хорооны нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах бөгөөд зөвхөн энэ хуулийн 10.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**12 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

12.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.21-д заасны дагуу ажлын хэсгийн гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээр” гэсний өмнө “болон” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “захиргааны,”, “тусгай” гэсний өмнө “төрийн” гэж нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтын “төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 6.1.13 дахь

заалтын “ажиглалт хийх” гэснийг “ажиглагчаар оролцох” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “замаар” гэснийг “аргаар” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүнийг” гэснийг “этгээдийг” гэж, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны” гэснийг “Хорооны” гэж өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Хүний эрхийн Үндэсний” гэснийг хасах.

4.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн найруулгын саналуудыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гаргасан найруулгын саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн 4 дүгээр зүйлд” гэж, “дараах хэсэг,” гэснийг “4.1.4 дэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 5.4 дэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “зүйлийн 21.2 дахь хэсэгт дараах” гэснийг “зүйлд доор дурдсан агуулгатай 21.2.4 дэх” гэж, мөн зүйлийн 21.2.4 дэх заалтын “мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 5.20 дугаар зүйл нэмсүгэй:

“**5.20 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих**

1.Хүний эрх хамгаалагчийг доромжлох, гүтгэх, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах арга хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Хоёр.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, ***анхны хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалдаа оръё. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2020 оны 5 сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр нар болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажиллав.

Ажлын хэсэг дээрх асуудлыг 2021 оны 01 дүгээр сарын 12, 18, 01 дүгээр сарын 25, 3 дугаар сарын 23-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцэж дараах танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг гаргалаа.

Тухайлбал, хуулийн үргэлжлэх хүрээний хэсэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрх хамгаалагчаас гадна гадаад улсын нутаг дэвсгэрт хүнээр хамгаалах үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэний эрх зүйн байдлыг зохицуулах харилцааг тусгаж нэр томьёоны хэсэгт хүний эрх хамгаалагч, хүнээр хамгаалах үйл ажиллагаанд тодотгож хуулийн зарчим хэсгийг хүнээр хамгаалагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон өөрчилж, хүнээр хамгаалагч нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль болон бусад хуулийг сахин биелүүлэх, шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ялгаварлан гадуурхахгүй байх, бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зэрэг зарчмыг тусгалаа.

Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, тэдний үйл ажиллагааг дэмжих, хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шуурхай арга хэмжээ авч ажиллах, байгууллагынхаа дотоод журамд хүний эрх хамгаалагчийн хуулийг хамгаалах зохицуулалтыг тусгах, сургалт зохион байгуулах гэх мэт тодорхой үүрэг хүлээхээр хуулийн төсөлд тусгасан.

Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны гишүүнийг сонгон шалгаруулах механизмыг илүү тодорхой болгох үүднээс комисс олон талын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс 4 гишүүн нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох зохицуулалтыг боловсруулав.

Хорооны гишүүн нь орон тооны бус байх бөгөөд хороонд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл хүлээн авах, баримт нотолгоо цуглуулах, хадгалах, мэдээллийн сан үүсэх зэрэгт хорооны гишүүний үйл ажиллагааг байнгын, тасралтгүй явагдаж байх нөхцөлийг хангах юм.

Хүний эрх хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдсан санхүүгийн нөөц, эх үүсвэр нь ил тод, нээлттэй байхаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд хүний эрх хамгаалагчийн санхүүгийн эх үүсвэрээ хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж, төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгалаа.

Ажлын хэсэг төслийн талаарх зарчмын зөрүүтэй 24, найруулгын шинжтэй 4, дагасан хуулийн төслийн талаарх 4 саналыг бэлтгэн томьёолж Та бүхэндээ тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Хэлэлцэж байгаа төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүн Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батзэвэгийн Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн. Ийм ажлын хэсэг оролцож байгааг Та бүхэндээ танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Н.Алтанхуяг гишүүн горимын санал.

Н.Алтанхуяг: Энэ хуулийн төслийг хэлэлцье гээд орж ирж байхад нь би бас саналаа хэлж байсан юм. Д.Цогтбаатар гишүүн уучлаарай.

Би таныг энэ хуулийн төслөө татаад авчхаач гэж хүсэж байгаа юм. Одоо тэр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн баахан сүр болж баахан амьтан сонгоод л, гаргаад л. Та нарыг ажлаа хий гэсэн шүү дээ.

Одоо надад тэр Т.Чимгээгийн ах Т.Хүрэлбат гэдэг хүнээс ирсэн өргөдөл байна. Б.Содномдаржаагийн ээжээс ирсэн өргөдөл байна. Та нар ажлаа хий л дээ. Одоо дахиад яагаад ийм хачин хууль бариад ингээд байгууллага яриад л, дахиад 7 хүнтэй нэг юм байгуулна гээд ингээд яваад байгаа юм бэ. Хэзээ ажлаа хийх юм бэ? Ийм хачин лобби юм яриад.

Би одоо та нарын хуулийг дотор талд нь ингээд би нэг бүрчлэн уншлаа. Ийм хууль гэж байхгүй. Давхардсан байна. Аливаа хэлбэрээр эвлэлдэн нэгдэх төрийн бус байгууллагын холбоо, бүлэг, нэгдэл байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох. Энэ чинь Үндсэн хуулиараа бүгдэд нь нээлттэй л

байгаа шүү дээ. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор тайван жагсаал, цуглаан санаачлан зохион байгуулах, оролцох, мэдээлэл түгээх. Нээлттэй л байгаа шүү дээ.

Гадаад улсын, бүс нутгийн, эсвэл олон улсын байгууллага, сүлжээтэй харилцан хамтран ажиллах. Энэ гадаадынхантай хамтран ажиллахыг хуульчилж яах гэж байгаа юм. Монгол Улс.

Ингээд энэ дотор байгаа юмнууд чинь тэртээ тэргүй Үндсэн хуулиар олгогдчихсон эрх байна. Би өөрийгөө ч гэсэн Хүний эрхийн дэд хороонд орсон. Би хүний эрхийг хамгаалагч гэж боддог юм. Тэгээд энэ дотор та нар нэг хэсгийг нь аваад хүний эрхийг хамгаалдаг. Нөгөө хэсэг нь хамгаалдаггүй хэсэг болоод хувирах юм уу? Ийм концепцын хувьд угаасаа явахгүй хууль байгаа юм. Үүнийгээ татаж ав л даа.

Одоо ингэж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг албадан гаргах тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтээр уулзах, зөвлөгөө өгөх, туслах. Ийм хууль байдаг юм уу? Яахаараа ийм ийм үйл ажиллагаануудыг нь ингээд тусад нь салгаж аваад хуульчлаад яваад байгаа юм.

Цахим мэдээллийг нууцлалын хэлбэрээр солилцох боломжтой байх. Цахим мэдээллийн нууцад хууль ёсоор. Энэ чинь бүгдээрээ ингээд хуульд байгаа юмнуудыг авчраад бичээд байна шүү дээ.

Тэгэхээр Д.Цогтбаатар гишүүн ээ. Хэдүүлээ жаахан ажил хийе. Энэ улс орондоо жаахан бодиттой юм хийе. Энэ байгууллага байгуулдаг 7 хүн. Дахиад та нар 7 хүнийг сонгох гэж. Би тэмдэглэсэн байна. Энэ 7 хүнийг сонгох гэж хэдэн хуудас цаас. Яршиг л байна шүү дээ. Одоо дахиад 4 хүнийг нэрийг нь дэвшүүлээд сонгоно. Комисс байгуулаад. Тэр Үндэсний Комисс нь сонгоно. Болио. Ажлаа хий.

Тэр Т.Чимгээ, Б.Содномдаржаа нар гээд ингээд улаан цайм хүний нүдэн дээр хэлмэгдчихсэн хүмүүсийнхээ эрхийг хамгаалаад өг л дөө. Та нарыг тэгж энд зөндөө юм болж байж бид сонгоо биз дээ. Дахиад юун хороо вэ? Одоо болиоч ээ. Дахиад хүмүүсийг ялгаварлан гадуурхаад байх юм. Хэн нь хүний эрхийг хамгаалдаг, хэн нь хүний эрхийг хамгаалахгүй байгаа юм. Бодитой ажил хий.

Энэ хуулиа татаж ав. Энэ чинь дахиад 7 хүнд мөнгө төгрөг, өмгөөлөгчдийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ хуулийн төслийг өргөн бариагүй л дээ. Их Хурлын гишүүд хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд санаачилсан. Ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Анхны хэлэлцүүлэг хийх гэж байгаа.

Мөн хүний эрх зөрчиж байгаа холбоотой асуудлаар манай Хууль зүйн байнгын хорооноос Хүний эрхийн дэд хорооны дарга Баттөмөрийн Энхбаяраар ахлуулсан ажлын хэсэг гарсан. Ажиллаж байгаа. Энэ хүрээндээ

Н.Алтанхуяг гишүүний ярьж байгаа, санаа зовж байгаа асуудлыг бид анхаарах ёстой.

Тэгэхээр хууль санаачлагч энэ хуулийнхаа төсөлтэй холбогдуулаад тодорхой тайлбар хэлэх үү.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр хийх юм нь олж ядаад оруулж ирээд байгаа юм байхгүй. Тийм юм бол харин байхгүй шүү. Одоо тэгвэл би ярья.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас бүр тусгайлан энэ дээр тогтоол гарч байсан. Үүнийхээ дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тусгайлан Мэри Лолор[Special Rapporteur on the situation of human rights defenders, **Ms.Mary Lawlor**] гэж хүнийг тусгай илтгэгч болгоод дэлхийгээр явуулаад судалгаа хийлгээд энэ дээр илтгэл гарсан байгаа.

Тэгээд энэ дээр юу гэж гарч байна вэ гэхээр “гайхалтай”. Үнэхээр манайд одоо энэ газар дээр энэ ажиллаад байгаа хүмүүс чинь дээрэлхээд, дарлаад, энд аюултай байна. Одоо яг энэ хүний эрхийн чиглэлээр ажиллаж байгаа **Amnesty International** эд нар чинь яриад байгаа юм.

Тэгсэн одоо энэ илтгэлийг уншихаар дэлхий дээр 64 оронд аягүй ноцтой зөрчлүүд байнга тогтмол гарч байна гээд. Тэгээд та нар ингээд боддоо. Энэ 64 чинь аягүй өндөр хөгжилтэй, аж үйлдвэржсэн, Европын хилийн чанад дахь өндөр аж үйлдвэржсэн, бидний хүний эрхийн дээд тэр эталоныг тавьж байгаа улсууд орчхоод яваад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дээр чинь үндэслээд дэлхий дээр хандлага гарч ирчхээд байна гээд. 2015 оноос хойш энэ статистикийг харахад 1300 хүн алагдсан байгаа юм. Би зүгээр амиа алдсан хүмүүсийг нь ярьж байна шүү.

Монголд бол аль хэдийн энэ янз бүрээр дарамталдаг, ар гэр бүл рүү нь утастдаг, айлгадаг юм чинь яваад байгаа юм. Дарга нар та нар аягүй өндөр хол байна. Энд 5 хүн томилчхоод тэгээд бүгдээрээ ингээд загнах юм. Ямар том дарга нар юм бэ. Эд нар чинь тэр дээрэлхдэг, дарамталдаг улсуудтай чинь ажиллаад эд нарын ажлыг хийлгэхгүй айлгаад байгаа байхгүй юу.

Тэр Т.Чимгээ эд нар дээр чинь дуугарч чадахгүй байгаа нь аргагүй шүү дээ. Эд нарыг зөрүүлээд яг тэгж чадах учраас. Тэр үед нь би гишүүн байгаагүй. Та нар дуугарч чадаагүй учраас эд нар чинь одоо энэ асуудлыг оруулж ирээд байгаа юм. Түүнээс амьдралгүй юм яриад байгаа биш.

Энэ хууль чинь өөрөө дэлхий дээр угаасаа яригдаад явагдаж байгаа процесс. Одоо жишээлбэл хүний эрхийн асуудал ерөнхий Үндсэн хууль, бүх юманд туссан байхад жишээлбэл Өмгөөллийн тухай хууль гэдэг чинь ахиад л нарийвчлаад орж ирдэг шүү дээ. Хууль дээр байгаа учраас орж ирэхгүй гээд.

“Special provisions” гээд энэ тусгай заалтуудтай хуулийг ингэж нэрлэдэг. Тэгж нарийвчилж хууль өөрөө хөгжиж байгаа юм.

Тэгээд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм дээрээ ч, ер нь олон улсын хууль дээр ч энэ **“The progressive development of international law”** гэж бүр нэрлэдэг. Тэр нь аливаа хууль өөрөө байрандаа зогсохгүй хөгжөөд явахыг хэлж байгаа юм.

Энэ хөгжил нь аргагүй энэ Монголд эрх зүйн норм, цоо шинэ норм орж ирж байгаа юм. Тийм учраас хүн тэр болгон ойлгохгүй байгаа нь бас үнэн байх.

Тэгээд энэ **“шүгэл үлээгч”**-ээсээ хүртэл ялгаж чадахгүй. Тэгээд юм л бол шүгэл үлээгчтэйгээр яриад л. Эсвэл энэ Хүний эрхийн комиссынхондоо дархан эрх өгчихсөн. Тэгээд түүнтэйгээ андуураад зүгээр **“хамгаалалт”**, **“дархан эрх”** хоёрынхоо ялгааг…/минут дуусав/

С.Бямбацогт: Одоо төсөл рүүгээ орчихъё. Тэгэх үү. Төслийн зүйл, заалт болгон дээр асуулт асуух боломжтой. Одоо төслийн зүйл болгоноор хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлэг.

Одоо ингээд та нар хуулийн төслөө болон дээрээс нь хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналуудыг харьцуулаад төслийн зүйл болгон дээр харж байгаад өөрсдөө асуултаа асуугаад, үгээ хэлэх бололцоотой. Одоо тэгэхээр хуулийн хэлэлцүүлэгтээ оръё.

Та сая хэлсэн. Одоо яах юм бэ. Одоо ингээд маргалдаад явах вэ. Горимын саналаа хэлсэн шүү дээ. Түрүүн. Нэгэнтээ Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдсэн шүү дээ. Хэлэлцэх эсэхийг шийдсэн хуулийг бид буцаах дэг байхгүй. Таны горимын санал. Харин татаж авахгүй гээд байна шүү дээ. Сая үгийг нь сонслоо шүү дээ.

Бид нэгэнтээ хэлэлцээд эхэлсэн асуудлыг бид буцаах эрх байхгүй. Зөвхөн хууль санаачлаад татаж авах бололцоотой. Гишүүд ээ. Тайван байцгаая.

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт оръё.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Нэг саналтай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, хамтран ажиллах, Хүний эрх хамгаалагчийн хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Туршилтын санал хураалт. Гишүүд ээ. Анхааралтай.

Одоо санал хураалт явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Сая би томьёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 56.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ш.Раднаасэд гишүүн, Ш.Адьшаа гишүүнээр тасаллаа.

Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Энэ түрүүн Н.Алтанхуяг гишүүний яриад байгаа бас буруу биш шүү.

Бид энэ хоёр их том улсын дунд байгаа. Би хүний эрхийг хамгаалагч гээд нэг тэмдэг зүүсэн, гардаа эсвэл нэг улаан бугуйвч зүүсэн нөхөд гарч ирээд нийгмийг самардаг, эмх замбараагүй байдлыг бий болгодог, жагсаал цуглаан зохион байгуулдаг. Би хүний эрхийг хамгаалагч гээд ингээд статус аваад. Түүгээрээ далимдуулж ингэж гардаг нэг ийм юм болох вий.

Энэ жагсаал, цуглаан зохион байгуулахад улс төрийн намууд оролцож байна гэж. Одоо ерөөсөө энэний чинь цаана энэ санхүүжилтийг төрийн байгууллага хэн нэгнээс авч болно гээд биччихсэн байна шүү дээ энэ дотор чинь. Тэр чинь өөрөө хууль ёсоор энэ хагалган бутаргах, энэ жагсаал, цуглаан зохион байгуулах, эмх замбараагүй байдал бий болох ийм юм руу явах вий. Энэ бол болгоомжлох сэдэв мөн шүү.

Бид энд их гоё юм бодоод, гоё юм хийгээд биччихдэг. Хууль ёсоор үүнийг нь баталгаажуулаад албан ёсоор өгчхөж байна.

Яах вэ, тэр гадна дотнын хуулиудаас, гадна дотнын байгууллагуудаас мөнгө төгрөг авахыг хориглоно гээд ингээд янз янзаар бичиж болно. Түүний чинь цаана янз янзын хэлбэрээр хуульд чинь нийцүүлээд энэ санхүүжилтийг нь бүр албан ёсоор өгүүлээд, хүний эрхийг хамгаалж байгаа нэртэй нийгмийн нэг жижигхэн асуудлыг бүр хэд дахин илүү өндөр хөөс болгож. Ингээд эргээд энэ улс орны чинь хувь заяа, аюулгүй байдал, тусгаар тогтнолтой чинь холбоотой юм болох вий гэж болгоомжлоод байгаа юм.

Тэгэхээр үүнийг аль аль талдаа сайн бодож хийхгүй бол өнөөдөр яах вэ дээ Нэгдсэн Үндэстний Байгууллагаас мянган гоё юм гарч болно шүү дээ. Тэрийг дагаж болно. Үүнийг яг улс орныхоо нөхцөлтэй тооцож, энэ монгол хүмүүсийнхээ тусгаар тогтнол, энэ монгол хүний өнөөдөр байгаа нөхцөл

байдал, энэ нийгмийнхээ орчин тойронтой бодож үүнийг хийхгүй бол бас болохгүй байх.

Зарим нэг зүйлүүдийг нь засах ёстой юм шиг харагдаж байна. Тэр санхүүжилт гаднаас болон хэн нэгэн этгээдээс ерөөсөө авдгийг нь болиулах хэрэгтэй.

Хоёр дахь юм нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх салбар нэгжийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт 1 минут. Ш.Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд байгаа зүгээр л нэг нэгжийг л ингээд хуульчлаад оруулаад өгчхөж байна шүү.

Үндсэн чиг үүрэг нь Хүний эрхийн комиссынхоо хууль дээр бол байгаа. Тэрийгээ хийдгээрээ хийгээд л явна. Үүний дэргэд дахиж хууль гаргаад яг ингээд **"хамгаалагч"** гэдэг ийм хаяг зүүж нэг хэсэг хүнд өгөх гээд байна шүү. Энэ чинь ерөөсөө тийм юм харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр ерөөсөө энэ дээр мэдээллийн ил тод байдлыг нь хангая. Өөр хүний эрхийг хамгаалдаг мянга мянган хэлбэр байгаа шүү дээ. Заавал нэг бүтэц байгуулж, бүтэц гаргаж ирж ингэж хамгаалах гээд. Тэр нь байхгүй болохоор хүний эрх зөрчигдөөд байгаа юм шиг ийм байдал харагдуулаад байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийг маш сайн бодолцож санал өгч явах ёстой болов уу гэж харж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулчих уу? Ц.Мөнхцэцэг гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ хуулийн төсөлд яг хүнээр хамгаалагч гэдгийг ашиг хонжоо хайсан, эсвэл тодорхой хүчирхийлэлд уриалан дуудсан ийм нөхдөөс ялгах хэд хэдэн шалгууруудыг оруулсан байгаа.

Ер нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд хүний эрхийн нэрээр гэдэг юм уу, хүний эрх хамгаалагчийн нэрээр тодорхой хэмжээний улс төрийн зорилгоор жагсаал, цуглаан, эсвэл хагалган бутаргах үйл ажиллагаа явуулдаг ийм тодорхой субъектүүд байсан. Үүний зэрэгцээ яг хүний эрхийн, уул уурхайн чиглэлээр, тухайн хүний эрхийг хамгаалагчийн тэмцлүүдийг ялгах ёстой.

Тийм учраас хуульдаа бид **"хүний эрх хамгаалагч"** гэдгийг хүчирхийллийн бус аргаар, тайван замаар. Тэгээд Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн конвенцүүдийг зөрчихгүй байхаар хамгаалж буй үйл ажиллагааг зааглан ялгаж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл энэ хууль маань яг хүний эрхийн төлөө тэмцэгч болон эсвэл тодорхой зорилгоор, улс төрийн зорилгоор үйл

ажиллагаа явуулдаг энэ бүлэг этгээдүүдээс маш сайн зааглан ялгаж өгсөн байгаа.

Хоёрдугаарт нь, энэ хууль маань олон улсын шинэ хүний эрхийн механизм нэвтрүүлж байгаа шинэ жишиг.

Ер нь Монгол Улс ардчилсан 30 жилийн хугацаандаа хүний эрхийн тогтолцоо маань төлөвшлийн шатандаа явж байгаа. Бид бас нэмэлт ийм механизм оруулж, хүний эрхийн үндэсний тогтолцоогоо сайжруулах шаардлагатай.

Тэгээд олон улсын жишгээр энэ Европын Холбоо гэх мэт бүс нутгийн хүний эрхийн томоохон байгууллагуудтай дотоодын хууль тогтоомжоор хүний эрхийн механизм хангалттай байгаа улс орнууд тусгайлан хууль гаргахгүй байгаа.

Гэтэл шилжилтийн улс орнууд болон Ази, Африк тэргүүтэй дарангуйллаас шилжиж байгаа улс орнуудын хувьд хүний эрх хамгаалагчийг хамгаалсан ийм тусгай зохицуулалт нь зайлшгүй шаардлагатай байгаа. Тийм учраас энэ хууль маань хүний эрхийн тогтолцоондоо дэвшил авчирч байгаа.

Дээр нь **“хүний эрх хамгаалагч”** гэдгийг бусад зорилгоор үйл ажиллагаа явуулдаг улс төрийн ийм ашиг хонжоо ологч бүлгүүдээс ялгаж байгаа учраас маш дэвшилттэй хууль болсон.

С.Бямбацогт: Ер нь сая Ш.Раднаасэд гишүүн, Н.Алтанхуяг гишүүний ярьж байгаа зүйлүүд хэлэлцэх эсэхийг хэлэлцэх явцад Байнгын хороо, чуулганы хуралдаан дээр нэлээн яригдсан. Ажлын хэсэг дээр нэлээн яригдсан. Энд бас нэлээн болгоомжлох ёстой хууль шүү гэдэг дээр Улсын Их Хурлын удирдлагуудын түвшинд ч бас нэлээн яригдсан.

Энэ хүрээндээ хуулийн хоёр дахь санал хураалтаар хуулийн хүрээ хязгаарыг нэлээн хумьсан. Үндсэн хууль болон энэ хуульд заасан хүрээнд үйл ажиллагаа явуулна гэснийг Үндсэн хууль болон Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна гэж бид хязгаарласан.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн өргөн хүрээтэй байсныг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зөвхөн хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гэж ийм байдлаар хумьсан.

Гэхдээ л бид бас анхаарах ёстой гэдэг дээр нэлээн сайн анхаарах ёстой. Гишүүд саналаа сайн бодож өгөөд санал хураалтаа явуулъя.

Төслөөрөө бол нэлээн өргөн хүрээтэй байсан. Ажлын хэсэг нэлээн ажиллаад нэлээн хумьж байгаа гэдгийг гишүүддээ бас хэлье.

Асуулттай холбогдуулж ажлын хэсэг л хариулах ёстой. Санал байхгүй. Санал хураалт дээр асуулт байгаа. Ш.Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Энэ хуулийн төслийг ер нь дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ Хүний эрхийн Үндэсний Комисс гээд Улсын Их Хурлын бүтцийн энэ байгууллага сонгогдоод ажиллаж байгаа. Энэ хүмүүсийн үйл ажиллагаанд сүүлд нь би бүр эргэлзэх байдал төрөөд байгаа юм.

Одоо энэ сүүлийн хэд хоногт Т.Чимгээг эрүүдэн шүүсэн гэдэг асуудал ингээд нийгэмд их асуудал тарьсан. Шуугиан дэгдээсэн. Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд гээд энэ нөхөр их сонин юм ярьсан шүү. Телевизээр гарсан.

Тэр хүний эрх зөрчсөн зөрчөөгүйг бид судалж байж шийднэ. Энд бараг л ямар учиртай юм. Би ойлгохгүй байгаа шүү. Б.Энхболд оо. Чамайг. Чи нэгэнт тэр бичлэг цацагдаад хүний эрх зөрчигдсөн байна гээд Монгол Улсын Ерөнхий сайд нь, Хууль зүйн сайд нь маш хариуцлагатай юм хийж байхад Хүний эрхийн Үндэсний Комисс эсрэг юм ярьсан. Б.Энхболд. Чиний бичлэгийг би бүр хадгалж авсан байгаа шүү.

Бид үүнийг зөрчсөн зөрчөөгүйг шалгаж бараг дүгнэлт гаргана гэж. Яах юм. Өнөөдөр тэгээд. Тэгэхээр Улсын Их Хурлын бүтцийн байгууллага чинь ийм хүний эрхэд хандаж байхад тэр бусад хүний эрх хамгаалагч тэр хүмүүсийг нь баталж өгье. Баталж үүнийг одоо тэр Ш.Раднаасэд гишүүний, Н.Алтанхуяг гишүүний яриад байгаа юмыг бас суулгаад үүнийг баталж гаргах шаардлагатай байгаа.

Бид Монгол Улсын хувьд олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон улс шүү. Бид НҮБ-ын гишүүн. Энэ олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон энэ эрх үүргээ биелүүлэхгүй бол бид яах юм. Бүх юмыг харлуулах, бүх юмыг харддаг энэ сэтгэлгээнээс салъя.

С.Бямбацогт: Ш.Адьшаа гишүүнд нэмэлт 1 минут.

Ш.Адьшаа: Хүний эрхийн Үндэсний Комисс ажлаа хий. Өнөөдөр манай эрх баригчид ярьж байгаа шүү дээ. Бид хамгийн сайн нийтийн сонсгол хийгээд маш сайн хүмүүсийг бид томилсон гэж. Би энэ томилогдсон хүмүүс дээр судалгаа явуулсан шүү. Хэн хэн ямар хүмүүсийг оруулж ирээд хэн томилсон юм. Ямар санал болгосон юм. Одоо тэр Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлд би бас ингээд саналаа хэлээд явж байгаа.

Та нар төрийн өмнө үүргээ биелүүлээрэй. Би дахин дахин үүнийг ярина шүү. Би тэр Т.Чимгээгийн асуудал. Б.Энхболд оо. Тэгээд та нар үүнийг өнөөдөр ямар байдлаар үүнийг унагаах гээд ийм юм яваад байгаа юм. Би бас их эргэлзэж байна.

С.Бямбацогт: Хариулах уу? Хариултгүй. Ц.Мөнхцэцэг гишүүн хариулах уу? Ц.Мөнхцэцэг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Ш.Адьшаа гишүүний хэлж байгаа санал бол үндэслэлтэй байгаа.

Ер нь Монгол Улсад хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон олон улсын болон дотоодын хууль тогтоомжууд дээр хүний эрхийг боломжийн түвшинд хангасан гэж байгаа боловч яг тодорхой бодит амьдрал дээр, ялангуяа эрүүдэн шүүсэн асуудлаар үнэхээр асуудал ихтэй байна.

Зөвхөн иргэн Т.Чимгээгийн хэрэг төдийгүй, нэлээд олон, жил бүр 20-иос доошгүй орчим гомдол, өргөдөл Хүний эрхийн Үндэсний Комисст ирдэг. Тийм учраас бид өнөөдрийн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиа батлахаас гадна дахиад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, гүйцэтгэх ажиллагаа гэдэг юм уу, процессын шатандаа эрүүдэн шүүх явдлаас хамгаалах ийм механизмуудыг оруулах шаардлагатай. Энэ дээр хараат бус. Эрүүдэн шүүхийг мөрдөх ийм комисс буюу хуучнаар нөгөө прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албыг сэргээх шаардлагатай байгаа.

Тийм учраас бид хүний эрхийн тогтолцоогоо дээшлүүлэх, сайжруулах, Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавхыг бэхжүүлэх зэрэг бүхий л ажлыг хийх шаардлагатай. Өнөөдөр байгаа хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр зарим нэгэн хувьд учир дутагдалтай байгаа учраас манай Их Хурлаас бодлогын түвшинд ийм ажлуудыг хийх нь зүйтэй байгаа.

Тэгээд энэ асуудал бол манай Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль бас тодорхой хэмжээгээр дөхөм болно. Энэ бол олон улсын томоохон шинэ тогтолцоог нутагшуулж байгаа ийм дэвшилтэт зүйл.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариултаа авчихлаа. Цахим байхгүй байсан уу? Тийм ээ. Одоо санал хураалт явуулъя.

Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй санал нэг байгаа. Түүгээр санал хураалт явуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үндсэн хууль,” гэсний дараа “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль” гэж нэмж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа” гэснийг “нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан, явуулж байгаа” гэж, “тодорхойлно” гэснийг “зохицуулна” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор. Туршилтын санал хураалт. Эхлээд. Санал хураалт.

Гишүүд байна. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 53.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Санал хураалт явуулъя.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсгийг нэмэх:

“3.2.Гадаад улсын нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэний эрх зүйн байдлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулна.”

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3-аар санал хураасан. Одоо 4 дүгээр зүйлтэй. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Ш.Раднаасэд гишүүн. Тасаллаа.

Ш.Раднаасэд: Энэ нэмэлт, өөрчлөлт хийж байгаа ажлын хэсгийн чинь томьёоллоор харахаар **“хүний эрх хамгаалагч”** гэж одоо байгууллага болж таарлаа. Тийм үү? Хүний эрх хамгаалагч байгууллага. Хүний эрх хамгаалагч гээд бас нэг хүн байгаад. Хажууд нь дахиад нэг байгууллага байх ёстой юм уу? Аль алиныг ойлгоод байгаа юм уу?

Зүгээр төрийн бус байгууллага чинь одоо нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэж хоёр ангилдаг шиг “хүний эрхийг хамгаалагч” гэж бас статустай дахиж гарч ирэх гээд байгаа юм уу? Тэр бол яах вэ НҮБ-ын дэргэдэх олон улсын сайн дурын үндсэн дээр нээлттэй.

Энэ ерөөсөө бүр ингээд зохион байгуулалт руу аваачиж хийж байгаа байхгүй юу. Одоо “хүний эрхийг хамгаалагч нам” мөн. “Хүний эрхийг хамгаалагч компани” мөн гэдэгтэй. Яг л ийм байдал руу оруулах гэж байна. Ийм статус авах гээд байна шүү дээ. Энэ “хамгаалагч” гээд нэр томьёог нь харахаар.

Уг нь орж ирсэн төслөөрөө бол энэ чинь “хүн” байсан юм байна. Ажлын хэсэг дээр гаргасан саналаараа энэ чинь “байгууллага”. Бүр “хуулийн этгээд” болоод яваад өглөө.

Тэгээд л түрүүний ярьдаг нөгөө улс төрийн зорилгоор хүний эрх хамгаалах нэртэй жагсаал, цуглаан, энэ үндэсний эв нэгдлийг бусниулсан, хагалсан, хугалсан юмнууд чинь энэ хэлбэрээр явна. Энэ бол яг зүгээр үүнийг нь хуулиар баталгаажуулаад өгчихсөн. Би ийм статустай. Бид эндээс ийм эрх дархтай орно. Төрийн байгууллага руу, ямар ч байгууллага руу орж мэдээлэл авах эрх бид нарт байна гээд л ингээд жагссан, цугласан ийм хэлбэр лүү бүх юмыг оруулж байна.

Тэгээд үүнийгээ дахиж ярихгүй юм уу? Энэ бол бүх нуухыг нь авах гээд бүр нүдийг нь сохлоод. Энэ шинэ оруулах гэж байгаа, хураах гэж байгаа саналаар чинь ажлын хэсэг чинь бүр аймаар болгоод хаячихлаа шүү.

Асуулт алга. Би зүгээр хэлэх санал л байна.

С.Бямбацогт: Бас хариулах нь зөв байх. Ойлголтын зөрүүнүүдээ арилгах. Тийм ээ. Нэгдсэн ойлголтод хүрэх ёстой байх. Ц.Мөнхцэцэг гишүүн. Ажлын хэсгийн ахлагч. Саяны бас эргэлзээтэй асууж байгаа, хэлж байгаа саналууд дээр нэг тайлбар хэлье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Энэ бол нөгөө "хүний эрхийг хамгаалагч" гэдэг бол яг энэ олон улсын загвар хуулиараа тодорхой тухайн асуудлаар тэмцэж байгаа иргэн. Жишээлбэл, одоо нөгөө хохирогчийн төлөө. Эсвэл тухайн эрх нь зөрчигдсөн бүлэг иргэдийн төлөө тэмцэж байгаа хувь иргэн байж болно. Эсвэл тухайн үйл ажиллагаанд хамтран оролцож байгаа бүлэг иргэд буюу. Жишээлбэл, тухайн асуудлаар жагсаал, цуглаан хийж байгаа. Эсвэл тухайн асуудлаар эсэргүүцэл гэдэг юм уу, гомдол, шаардлага тавьж байгаа иргэдийн нэгдэл байна.

Түүнээс биш яг ийм албан ёсны төрийн бус байгууллагад "хүний эрх хамгаалагч" гэдэг ийм статус олгоод явахгүй байгаа шүү. Өөрөөр хэлбэл яг тухайн үйл ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд бид "хүний эрх хамгаалагч" гэж үзнэ.

Тийм учраас энэ бол ийм ганцаараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн хүмүүсийг "хүний эрх хамгаалагч" гэж ойлгоно. Түүнээс биш хэн нэгэнд ингээд "хүний эрх хамгаалагч" гэдэг ийм тусгай цол, хаяг өгөөд бүрэн эрхийг нь урьдчилан баталгаажуулах явдал биш байгаа шүү. Энэ дээр яг үйл ажиллагаатай холбогдуулан олон улсын жишгээр ингэж явсан байгаа.

С.Бямбацогт: Санал хураалтаа явуулъя. 4 дүгээр зүйл. Тийм ээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."хүний эрх хамгаалагч" гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;

4.1.2."хүний эрх хамгаалах үйл ажиллагаа" гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын

эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалах;

4.1.3.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” гэж төр, хүн, хуулийн этгээд, тодорхой ашиг сонирхлоор нэгдсэн аливаа этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн байгууллагын үүргийг;

4.1.4.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага хүн, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;

4.1.5.“хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж Хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг аливаа хэлбэрээр доромжлох, гүтгэх, худал мэдээлэл тараах, ялгаварлан гадуурхах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөж мөшгөх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.6.“эрсдэлийн үнэлгээ” гэж хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчид учирч буй аюул, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон дүгнэлтийг.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 56.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан гишүүдээс санал алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя.

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**5 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

5.1.Хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.1.1.Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх;
5.1.2.шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх;

5.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
5.1.4.ялгаварлан гадуурхахгүй байх;
5.1.5.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 68.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя.

6.Төслийн ХОЁРДУГААР БҮЛГИЙН гарчгийн “ХАМГААЛАГЧИЙН ЭРХ,” гэсний дараа “САНХҮҮЖИЛТ,” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 68.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс гарсан санал алга байна. Дараагийн санал хураалт.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “хамгаалахад” гэснийг “хамгаалах үйл ажиллагаа явуулах, сайн дураар” гэж, 6.1.2 дахь заалтын “таниулах, тэдгээрийг” гэснийг “олон нийтэд таниулах,” гэж өөрчилж, төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хүний эрх хамгаалагч дараах бүрэн эрхтэй:”

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

8.Төслийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон гадаад улсын, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ш.Адьшаа гишүүн, Б.Энх-Амгалан гишүүдийг ирцээс хасаарай. Б.Энх-Амгалан гишүүн эмнэлгийн чөлөө авсан. Ш.Адьшаа гишүүн бас чөлөө авч байна. Ирцээс. Тийм. Санал хураалтаас бас хасагдана шүү дээ. Тэгэхгүй бол болохгүй шүү дээ. Тийм. Ш.Адьшаа гишүүн сая өөрийн биеэр хэлсэн. Б.Энх-Амгалан гишүүн бас хэлсэн шүү. Манай хуралдаан зохион байгуулах анхаарч байгаа биз.

Дараагийн санал хураалт.

9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.7.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдээс хуульд заасан аргаар хайх, олж авах, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “үүнийгээ хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх,” гэснийг, 6.1.10 дахь заалтын “төрийн үйл хэрэгт оролцох,”, “шүүмжлэх,”, “зөвлөмж хүргүүлэх,” гэснийг, 6.1.13 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэснийг, мөн зүйлийн 6.1.4, 6.1.14, 6.1.15, 6.1.18 дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.16 дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын “этгээдийн” гэсний дараа “бичгээр гаргасан” гэж, 6.1.12 дахь заалтын “үйлдлийн талаар” гэсний дараа “холбогдох олон улсын гэрээнд заасан журмын дагуу” гэж нэмж, 6.1.13 дахь заалтын “олон улсын холбогдох хэм хэмжээг” гэснийг “Монгол Улсын олон улсын гэрээг” гэж, 6.1.17 дахь заалтын “сэтгэл санааны болон бодит хохирлоо” гэснийг “эдийн болон эдийн бус хохирлоо хуульд заасан журмын дагуу” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Зарчмын хоёр санал байгаа юм байна.

13.Төслийн “**ХОЁРДУГААР БҮЛЭГ**”-т доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“**7 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод, нээлттэй байдал.**

7.1.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон аливаа санхүүгийн нөөц, эх үүсвэр ил тод, нээлттэй байх бөгөөд санхүүгийн нөөц дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

7.1.2.хуульд заасны дагуу төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;

7.1.3.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

7.2.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүжилтэд дараах нөөц, эх үүсвэрийг хориглоно:

7.2.1.Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно;

7.2.2.хуулиар хориглосноос бусад аргаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулахыг хориглоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Энэ маш чухал заалт орж байгаа юм байна шүү. Үүнийг байнга анхаарч ажиллах ёстой бид нар. Санал хураалт.

Ш.Раднаасэд гишүүний бас болгоомжлуулаад байсан заалтууд энд бүгд орсон байна шүү. Ш.Раднаасэд гишүүн ээ.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж, 7.1.3 дахь заалтын “хүний эрх, эрх чөлөөг, үл хүндэтгэх, зөрчих” гэснийг “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энэ бас чухал заалт байна.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүү буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс 7 дугаар зүйлтэй холбогдуулан бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Д.Цогтбаатар гишүүн. Тасаллаа.

Д.Цогтбаатар гишүүн асуултаа асууя. Ажлын хэсгээс.

Д.Цогтбаатар: Тэгэхээр энэ 8.1.3 дээр нэг ийм юу байгаа юм. Энэ ерөөсөө угаасаа хуульдаа цаанаасаа суугаад өгчихсөн байгаа асуудлуудыг эхнээс нь ингээд тодотгоод оруулаад байгаа юм байна.

Тэгэхээр би юу хэлмээр байна вэ гэхээр анхны энэ хууль санаачилж орж ирэхэд байсан энэ санааг нь бас үлдээж өгч болохгүй юм уу гэдэг. Өөрөөр хэлбэл тэр ерөнхий, анхнаасаа орж ирсэн тэр санааг нь авч үлдмээр байна. Энэ дээр хамаагүй өөрчлөөд явмааргүй байна. Тэр өөрчилж байгаа санаа нь угаасаа анхны агуулгадаа орсон байгаа гэдгийг л би анхаарч үзээсэй гэж бодоод байгаа юм.

Түүнээс гадна зүгээр энэ боломжийг ашиглаад Хүний эрхийн хорооныхон гишүүн санал эсэргүүцэх юм бол Хүний эрхийн Үндэсний Комисстоо гомдлоо гаргах эрхтэй гээд заагаад оруулсан байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ зохицуулалт угаасаа цаанаасаа байж байгаа. Тийм учраас үүнийг бас засаж оруулахдаа ч гэсэн бид энэ агуулга нь цаанаа байгаа шүү гэдгийг санаж хийвэл зүгээр байгаа юм гэж хэлмээр байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: 8.1-ийн 5 заалттай байсан юм байна. 8.1 дээр 7 болгож байгаа юм. Ц.Мөнхцэцэг гишүүн хариулах уу? Өөр ажлын хэсгээс хариулах уу? Нэмж.

Ингэсэн юм байна. Хүний эрх. 7.1.3 дээр хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх, зөрчих. Хүний эрх хамгаалагч хориглох заалт. Ийм заалттай байсан байна. Үүнийг бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааж болохгүй гэж хориглох заалтаар оруулсан юм байна.

Улам сайн болсон байна шүү дээ. Сая санал хураачихсан. Тийм. Санал хураагдсан юм байна.

8 дугаар зүйлээр дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Уншаагүй байгаа билүү. Санал хураалт хүчингүй болгоорой.

15.Төслийн Гуравдугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

8 дугаар зүйл.Нийтлэг үүрэг

8.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх;

8.1.2.үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;

8.1.3.хүчирхийллийн бус, тайван аргаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх;

8.1.4.шаардлагатай мэдээллээр хангах;

8.1.5.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрх хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;

8.1.6.хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах;

8.1.7.хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг бичгээр гомдол гаргагчид болон Хүний эрх хамгаалагчийн хороонд хүргүүлэх.

8.2.Цагдаагийн байгууллага хүний эрх хамгаалагчид халдсан халдлагыг таслан зогсоох, түүнийг өөрийнх нь зөвшөөрснөөр эсхүл энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авна.

8.3.Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 64.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Хүний эрх хамгаалагчийг төрийн байгууллагынхан хааж боогдуулаад байвал ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдгийг. Би ингээд уншихаар. Эсвэл Төрийн албаны тухай хуульд заасан, эсвэл Зөрчлийн хууль гэсэн л хариуцлага байна л даа.

Эрх хамгаалагч хүн өөрөө шаардлагаа тавиад яваад байхад. Би зүгээр иргэн гэдэг утгаас нь биш байна. Төрийн албан хаагч гэдэг нь. Тийм ээ. Ямар нэгэн байдлаар та бүхний тавьж байгаа шаардлагыг биелүүлэхгүй юм уу, санаатайгаар хааж боогдуулах ч юм уу, асуулгад чинь хариу өгөхгүй байх ч юм уу. Одоо зөндөө байгаа шүү дээ. Энэ чинь. Тийм ээ. Зөндөө л яриад байгаа шүү дээ. Тэр тэгсэн. Энэ ингэсэн байна. Тийм ажиллагаа явуулсан байна. Ингэсэн байна гээд.

Тэгээд ямар хариуцлага хүлээлгэх вэ? Эрүүгийн хуулийн хариуцлага гэж ямар хариуцлага байна. Эрүүгийн хууль дээр байгаа хариуцлагыг хэлж өгөөч.

Эрүүгийн хууль гэсэн үг байна л даа. Энд. Зүгээр яах вэ, иргэд бол нэг их айхтар нарын эрхийг зөрчөөд байхгүй байх л даа. Тэр цагдаа энэ тэр нь очоод зохицуулчхаж болох байлгүй.

Хамгийн гол нь эрх бүхий. Тэр хүний эрхийг зөрчиж байгаа эрх бүхий төрийн албан хаагчид. Тэр тохиолдолд яах вэ гэдгийг нь. Тэгээд энэ хууль чинь өөрөө ингээд нэг тийм тунхаглалын шинж чанартай болно шүү. Хариуцлага нь тодорхой биш бол.

Манайхан ер нь энэ хариуцлагаа их орхигдуулдаг юм. Хууль зүйн байнгын хороо энэ талаас нь ярьдаг баймаар юм. Тийм ээ. Би хариулт сонсъё.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Ц.Мөнхцэцэг гишүүн хариулъя. Хариуцлагатай холбоотой. Хууль зөрчигчид ямар хариуцлага хүлээх вэ. Ялангуяа эрүүгийн хуультай холбоотой гээд.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, яг хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хууль дээр бид 5.20 дугаар зүйл гэдэг

шинэ зүйл нэмж оруулж байгаа. Тухайлбал, “хүний эрх хамгаалагч”-ийг доромжлох, гүтгэх, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах арга хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж Зөрчлийн хуулиар арга хэмжээ авахаар заасан байгаа.

Мөн адилхан. Тухайн хүний эрх хамгаалагч хүнээр хамгаалуулах үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа мөн хүчирхийллийн арга хэрэглэсэн. Энэ хуулийнхаа тодорхой заалтуудыг зөрчсөн тохиолдолд мөн адилхан Зөрчлийн тухай хуулиар тодорхой хэмжээний мөнгөн дүнгээр. Энэ маань хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний. Хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж байна. Зөрчлийн хуулийн юмнуудыг оруулсан байгаа.

С.Бямбацогт: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би Зөрчлийн хуулиар. Хамгийн гол нь ийм л байгаа юм л даа. Ц.Мөнхцэцэг гишүүн ээ.

Юу байна вэ гэхээр иргэдийн зөрчиж байгаа юм уу, тэр эсэргүүцэж байгаа байдал энэ тэр нь бол шийдэгдээд явчихна. Хамгийн гол нь энэ хүмүүс чинь эрхээ хэрэгжүүлээд явах гэхээр хууль хяналтуудын байгууллагуудын энэ хуулийг биелүүлэхгүй байх, энэ хүмүүсийн тавьж байгаа шаардлагыг биелүүлэхгүй байх тохиолдол нийгэмд чинь хавтгай байгаа юм биш үү. Том дарга нар чинь бүгд л яриад байна шүү дээ.

Тэгэхээр чинь энэ тохиолдолд яах вэ гэдэг нь. Энэ хуулиа биелүүлдэг байх ёстой. Биелүүлээгүй бол тэр хүн яах вэ. Албан тушаалаасаа огцрох уу, буух уу. Эсвэл эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх үү гэдэг нь нягт нарийн тодорхой байх ёстой л гэж хэлж байгаа юм. Би тодруулчихлаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Хариулах уу? Манай ажлын хэсэг ч бас анхааралдаа аваарай. Цаашдаа.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Ажлын хэсгээс бэлдсэн саналаар санал хураалт явуулъя.

Одоо 16. 10 дугаар зүйл дээр. 9 дүгээр зүйл дээр санал байхгүй. Тийм ээ. Асуулт асуух гишүүд байхгүй. Асуулт алга байна.

10 дугаар зүйл. Асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулт байхгүй учраас санал хураалт явуулъя.

16.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**10 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хороо**

10.1.Хүний эрхийн Үндэсний Комиссын /цаашид “Комисс” гэх/ дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг

бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо (цаашид “Хороо” гэх) ажиллана.

10.2.Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Хорооны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.

10.3.Хороо үйл ажиллагаагаа бие даан явуулах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах;

10.3.2.гомдол мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах;

10.3.3.хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх;

10.3.4.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комисст хүргүүлэх;

10.3.5.энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах;

10.3.6.гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх.

10.4.Хороо нь энэ хуулийн 10.2-т заасан даргаас гадна зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 11.3-т заасан хоёр нэр дэвшигчийг шууд, бусад дөрвөн гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс нэр дэвшүүлэн, нээлттэй сонсголоор сонгон шалгаруулж, Комисс батламжилна.

10.5.Хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо жендэрийн тэнцвэртэй байдал болон үндэсний хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчийн олон талт төлөөллийг хангана**.**

10.6.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

10.7.Хорооны гишүүн улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

10.8.Хорооны үйл ажиллагааны урсгал зардлыг Комиссын төсөвт тусгах бөгөөд Хорооны гишүүнд урамшуулал олгох журмыг Комисс батална.

10.9.Хорооны ажиллах журмыг Комисс батална.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Би зэрэгцээд ZOOM-д орсноос болоод Төрийн байгуулалт. Миний ирц орсонгүй. Энэ санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Би буцаж орохоос. Харин тийм. Гарахаас.

Саяны санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Хоёр зэрэг ZOOM-д орж болдоггүй юм байна. Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Одоо санал хураалтаа явуулъя. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 8 гишүүн буюу 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Санал хураалт явуулъя.

17.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:

11.1.1.хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай;

11.1.2.хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм, хэмжээний талаар мэдлэг, туршлагатай;

11.1.3.сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 64.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11.2, 11.3 дахь хэсэг болгох:

“11.2.Хорооны гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс дараах үе шатаар сонгоно:

11.2.1.Комисс нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Комисс, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

11.2.2.ажлын хэсэг Хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30 хоногийн хугацаанд нийтэд мэдээлэх;

11.2.3.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.2-т заасан хугацаа дуусанаас хойш ажлын гурван өдрийн дотор сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчийн хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг Комиссын цахим хуудаст байршуулах;

11.2.4.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.3-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах;

11.2.5.Ажлын хэсэг энэ хуулийн 11.1-т заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулах;

11.2.6.Ажлын хэсэг нээлттэй сонсгол зохион байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор нууц санал хураалт явуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор Хорооны гишүүнээр сонгох.

11.3.Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Комисс батална.”

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 8 буюу 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.5.Хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

8 гишүүн буюу 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.3 дахь заалтын “гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон” гэснийг “гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.” гэж, 11.7 дахь хэсгийн “Хороо боловсруулж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос баталж, мөрдүүлнэ” гэснийг “Комисс батална” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 8 гишүүн буюу 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

22.Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“**12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хорооны нэгж**

12.1.Хорооны гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах бөгөөд бүтэц, орон тоог Комисс батална.

12.2.Хорооны нэгжийн ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

12.3.Хорооны нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах бөгөөд зөвхөн энэ хуулийн 10.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.”

Бас дотроо дахиад нэгжтэй байх юм уу? Тийм ээ. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

14 гишүүнээс 8 гишүүн байна. 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хороо нь орон тоо бус учраас нэгж байхгүй бол болохгүй юм байна.

23.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**12 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

12.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн оролцсоноос 64.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрс байна уу? Санал байна уу? Санал арга байна.

13 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Ажлын хэсгийн бэлдсэн саналаар санал хураалт явуулъя.

24.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. Одоо найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээр” гэсний өмнө “болон” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “захиргааны,”, “тусгай” гэсний өмнө “төрийн” гэж нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтын “төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 6.1.13 дахь заалтын “ажиглалт хийх” гэснийг “ажиглагчаар оролцох” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “замаар” гэснийг “аргаар” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүнийг” гэснийг “этгээдийг” гэж, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны” гэснийг “Хорооны” гэж өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Хүний эрхийн Үндэсний” гэснийг хасах.

4.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Одоо Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя.

Нэг.Гэр, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн 4 дүгээр зүйлд” гэж, “дараах хэсэг,” гэснийг “4.1.4 дэх” гэж өөрчлөх.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр санал хураалт явуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 5.4 дэх” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байна уу? Байхгүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Төслийн 3 дугаар зүйлээр ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалт явуулъя.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “зүйлийн 21.2 дахь хэсэгт дараах” гэснийг “зүйлд доор дурдсан агуулгатай 21.2.4 дэх” гэж, мөн зүйлийн 21.2.4 дэх заалтын “мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 5.20 дугаар зүйл нэмсүгэй:

“**5.20 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих**

1.Хүний эрх хамгаалагчийг доромжлох, гүтгэх, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах арга хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.””

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байна уу? Алга байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон. Тийм үү. Санал хураах уу? Тийм ээ.

Энэ түрүүн 7 дугаар зүйл дээр бид нэг санал хураалт дээр бас нэг зарчмын алдаа гарсныг засъя. Доор нь засах нь зөв байх.

7 дугаар зүйлийн 7.2.2.хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулахыг хориглоно.”

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энэ бол маш чухал заалт шүү. Санал хураалт.

Тэгэхгүй бол нөгөө янз янзын эх үүсвэрээс санхүүжилт аваад байх. Нөгөө Н.Алтанхуяг гишүүн бас яриад байгаа асуудлууд үүсэх бас эрсдэл байна.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнхцэцэг гишүүн танилцуулна.

Одоо дараагийн асуудалдаа орно.